# НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯАМНЫ ТУШААЛ, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1981 оны 3 дугаар сарын 16 -ны өдөр

Дугаар 64/55

Улаанбаатар хот

## ЗОЧИД БУУДАЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нийтийн аж ахуй үйлчилгээний яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1.Багануурт 40 ортой зочид буудлыг 1981 оны 3-р сарын 1-нээс эхлэн байгуулж, Налайхын нийтийн аж ахуй үйлчилгээний газрын харьяалалд ажиллуулсугай.

2.Зочид буудлын 1981 оны орон тоо цалингийн фондыг хавсралтаар баталсугай.

3.Аймаг, хотуудад 1981 оны 20 дугаар тушаалаар хуваарилсан зочид буудлын мебелээс 2 комплектыг хасаж Багануурын зочид буудалд өгөхөөр Налайхын нийтийн аж ахуй үйлчилгээний газар олгохыг НААҮЯ-ны материал техникийн хангамжийн хэлтэс /н.Дагва/-т даалгасугай.

4.Үндсэн ба эргэлтийн хөрөнгө бэлтгэхэд шаардагдах хөрөнгө гаргаж өгөхийг НААҮЯ-ны Барилга засвар, хөрөнгө оруулалтын хэлтэс /н.Сүхбат/, Улаанбаатар хотын төлөвлөгөөний комисс /н.Сумаахүү/, Санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т даалгасугай.

5.Шаардлагатай тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгийг олж 1981 оны 3-р сарын 15-ны дотор зочид буудлыг ажилд оруулахыг Багануурын АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Очиррагчаа/, Налайхын нийтийн үйлчилгээний газар /н.Дэлэг/-т үүрэг болгосугай.

НИЙТИЙН АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯАМНЫ САЙД О.НЯМАА

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

ЯАМ

НАА, Улаанбаатар хотын АДХ-ын
Гүйцэтгэх захиргааны 1981 оны
-р тогтоолын
хавсралт

# БАГАНУУР ДАХЬ 40 ОРТОЙ ЗОЧИД БУУДЛЫН 1981 ОНЫ ОРОН ТОО ЦАЛИНГИЙН ФОНДЫН ТӨСӨВ

*1981 оны 156/152-р тогтоолоор хүчингүй.*

| Албан тушаал | Орон тоо | Сарын цалин | Жилийн цалин |
|---|---|---|---|
| 1. Цагаан хэрэгслэлийн нярав ба буудлын жижүүр | 3 | 525 | 15750 |
| 2. Үйлчлэгч | I | 300 | 3000 |
| 3. Цэвэрлэгч | I | 260 | 2600 |
| 4. Бохир усны цэвэрлэгч | I | 330 | 3300 |
| 5. Сантехникийн слесарь | I | 400 | 4000 |
| ДҮН | 7 | - | 28650 |